



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№30 /244/

2022.02.14



Монгол цэрэг энхийн үйлсэд

ЦЭНХЭР ДУУЛГАТАН БҮСГҮЙЧҮҮД ҮЗҮҮЛЭХ ТОГЛОЛТОД БЭЛТГЭЖ БАЙНА



Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны 20 жил, олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан эмэгтэй энхийг сахиулагчдын чуулга уулзалт ирэх 3 дугаар сарын 4-ний өдөр Соёлын төв

өргөөнд болох юм. Мөн эл өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд эмэгтэй энхийг сахиулагчдын гардан тулааны болон жагсаалын үзүүлэх тоглолтыг зохион байгуулах бөгөөд бэлтгэлийг Зэвсэгт хүчний 032, 084 дүгээр ангийн

байрлалд базааж байна. Дээрх үзүүлэх тоглолтод Улаанбаатар цэргийн хүрээний анги, байгууллагуудын 40 эмэгтэй цэргийн алба хаагч оролцож байгаа юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчин тэр дундаа эмэгтэй цэргийн алба

хаагчдын бүрэлдэхүүний ажил мэргэжил, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, иргэд, залуучууд, өсвөр үеийнхэнд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа юм.



Түүхэнд энэ өдөр

1945 он.

Крымын Ялта хотод хуралдсан хурлаас БНМАУ-ын статус-кво-г хүлээн зөвшөөрчээ.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-15	-34


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
34	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,856.00	2,859.0
EUR	3,253.0	3,265.0
CNY	448.50	449.50
RUB	38.50	39.00
JPY	24.55	24.75
KRW	2.40	2.41

ЗУРХАЙ



2022.02.14 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЫН 13/

ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САРЫН ГУРВАН ХӨХ ШАР НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

ЖАРГАЛ ИРНЭ.

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.01-18.12

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Нэр өнгө

Суудал: Төмөр

Энэ өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, лус тахиx, хүүхэд үрчлэн авах, гэр, байшингийн суурь тавихад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Тэрсүүд өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.

ДОРНЫН ЗУРХАЙ: Үс засуулвал жаргал ирнэ

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,270,372 /69.8%	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,171,612 /66.8%	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,013,996 31,0%
---	--	--

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 8138 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 130	ЭДГЭРСЭН 7891
------------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 412,169,871
Эдгэрсэн Нийт: 332,703,741
Нас барсан Нийт: 5,834,095



Цахим шууданд

"ЦЭВЭР АГААР-ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН"

Зэвсэгт хүчний 017 дугаар анги
 Ангийн "Ахлагчийн зөвлөл" төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүний дархлааг дэмжих, эрүүл зөв дадал хэвшил, идэвхтэй амьдралын хэв маягтай ахлагч зорилгын хүрээнд "Цэвэр агаар-Идэвхтэй хөдөлгөөн" явган аяллыг Богдхан уулын Баруун ширээтийн оргил, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн гэсэн маршрутын дагуу


2 үе шаттайгаар зохион байгууллаа. Аяллын хөтөлбөрийн 1 дүгээр шатны хүрээнд тус ангийн ахлагчийн бүрэлдэхүүн Богдхан уулын дурсгалт газруудтай танилцаж, цасны сумо, хөгжөөнт буухиа тэмцээнийг зохион байгуулав. Тэгвэл 2 дугаар шатны хүрээнд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцлаа. Энэ үеэр

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн удирдлага хүлээн авч, хүрээлэнгийн үйл ажиллагаа, зорилго зорилтыг бие бүрэлдэхүүнд танилцуулав. Аялалын төгсгөлд "Монгол цэрэг энхийн үйлсэд" дурсгалын цогцолборын талбайн цас, эргэн тойрны хогийг цэвэрллээ. **Тэргүүн ахлагч А.ЦЭРЭНТОГТОХ**



"ЦАСНЫ СУМО"-НЫ АВАРГУУД ТОДРОВ

Зэвсэгт хүчний 167 дугаар анги
 2022 оны 2 дугаар сарын 12-ны өдөр хугацаат цэргийн алба хаагчдын дунд "Цасны сумо" бөхийн тэмцээнийг зохион явууллаа. Тэмцээнд 28 байлдагч оролцсон бөгөөд тэргүүн байрт миномётын батарейны байлдагч Б.Сэргэлэнбаяр, дэд байрт танкийн ротын байлдагч Б.Есөн-Эрдэнэ нар шалгарлаа. **Дэслэгч Б.БАТЗАЯА**



"ДЭЭЛТЭЙ МОНГОЛ ӨДӨРЛӨГ" ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 234 дүгээр анги
 2021-2022 оны сургуулийн жилд алба, салбар сурталчлах 14 хоногийн аяныг урлаг, спортын уралдаан, тэмцээнүүдэд бие бүрэлдэхүүний оролцох идэвхийг нэмэгдүүлэх, гар нийлэмжтэй ажиллагааг хангаж нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор эхлүүлээ. Тус аяны хүрээнд энэ сарын 10-ны өдөр Захиргааны удирдлага, сургалт, соёл хүмүүжлийн албанаас Монгол цэрэг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож

эхэлсний 20 жилийн ойн нэрэмжит "Үндэсний өв уламжлалаа дээдэлэе" уриатай "Дээлтэй монгол өдөрлөг"-ийг амжилттай зохион байгуулав. Өдөрлөгийг бэсрэг наадам хэлбэрээр зохион байгуулж, багийн гишүүдийн мэндчилгээ, шагай шүүрэх, сээр цохих, шилбэ зангидах, ерөөл, магтаал зохион бичих, шилдэг хос дээл шалгаруулах гэх мэт тоглоом наадгайгаар өрнүүлээ. Мөн энэ үеэр "Монгол ёс заншил сэдэв"-ээр захирагчийн орлогч, захиргааны удирдлагын тасгийн дарга хошууч Э.Эрхэмбаяр бие

бүрэлдэхүүнд мэдээлэл хийлээ. Өдөрлөгийн хүрээнд зохион байгуулагдсан уралдаан цэмцээнд Авто тээвэр засварын салаа, Инженер техникийн албаны хамтарсан "Язгууртан" баг тэргүүн байр эзэлж, үндэсний өв соёл, ёс заншлаа түгээж, эх түүхээрээ бахархах сэдлийг төрүүллээ. Түүнчлэн эл арга хэмжээнд энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдынхаа гэр бүлийг урин оролцуулж, ангийн үйл ажиллагаатай танилцуулж, хүндэтгэл үзүүлсэн юм. **Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ**

ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ДАДАЛ ЗУРШЛЫГ БИЙ БОЛГОЁ



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги
 2021-2022 оны сургуулийн жилийн сэтгэл зүйн хангалтын төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүний дархлааг дэмжих, ажлын стресс тайлах, эрүүл амьдралын дадал зуршлыг бий болгох зорилгоор "Мөсний баяр"-ын арга хэмжээг зохион

байгуулж явууллаа. Арга хэмжээний хүрээнд салбаруудын мэндчилгээ, цасны сумо, олс таталтын тэмцээн зэргийг зохион байгуулав. Олс таталтын тэмцээний тэргүүн байрт Үлээвэр найрал хөгжмийн баг, дэд байрт штабын баг шалгарлаа.

Цасны сумо тэмцээний эрэгтэй төрөлд тэргүүн байрт ахлах дэслэгч Г.Батболд, дэд байрт ахмад О.Мягмарцэрэн нар шалгарсан бол эмэгтэйчүүдийн төрөлд тэргүүн байрт Н.Энхтуяа, дэд байрт дэслэгч Р.Билэг нар шалгарсан юм. **Дэслэгч Р.БИЛЭГ**